

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### **БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Банкны тухай хуулийн дараах зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй.

#### **1/5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг:**

“5.3.Төрийн байгууллага нь энэ хуулийн 7.2-т заасан журмын дагуу олж авсан мэдээллийг өөр зорилгоор ашиглахыг хориглоно.”

#### **2/10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг:**

“10.4.Банкны өөрийн нэрийн өмнөөс зээл олгох үйл ажиллагаанд төр аливаа хэлбэрээр оролцохгүй.”

#### **3/17 дугаар зүйлийн 17.6<sup>1</sup> дүгээр хэсэг:**

“17.6<sup>1</sup>.Банкны тогтолцооны дэд бүтцийг хөгжүүлэх зорилго бүхий банкуудын дундын өмчлөлийн хуулийн этгээдийн хувьцааг 6.1.12-д заасан хүрээнд банк эзэмшиж болно.”

#### **4/32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэг:**

“32.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь банкны гүйцэтгэх захирлаас бусад аливаа албан тушаалтан, ажилтан байхыг хориглоно.”

#### **5/35 дугаар зүйлийн 35.9 дэх хэсэг:**

“35.9.Банк нь өөрийн үйл ажиллагааны онцлог, хүлээж болзошгүй материаллаг эрсдэлийн төрөл, түвшинтэй уялдуулан боловсруулсан аргачлалын дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон хөрвөх чадварыг үнэлэх бөгөөд уг аргачлалд тавигдах шаардлагыг Монголбанк журмаар тогтооно.”

#### **6/36 дугаар зүйлийн 36.21 дэх хэсэг:**

“36.21.Хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр нийтийг хамруулан хувь тэнцүүлэн олгосон хувьцааны эзэмшлийн хувьд энэ хуульд заасан холбогдох этгээд, болон харилцан хамаарал бүхий этгээдэд хамаарахгүй.”

#### **7/41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсэг:**

“41.4.Аудитын байгууллага /аудитор/ нь энэ хууль болон Аудитын тухай хуульд заасан шаардлагыг хангаж ажиллаагүй тохиолдолд аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгуулах саналыг

Монголбанкнаас санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж, шийдвэрлүүлнэ.”

**8/43 дугаар зүйлийн 43.7, 43.8, 43.9, 43.10, 43.11 дэх хэсэг:**

“43.7.Монголбанк энэ хуулийн 35.9-д заасан үнэлгээг хянан баталгаажуулах хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг журмаар батална.

43.8.Банкны хяналт шалгалтын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Монголбанк шаардлага, мэдэгдэл зэрэг захиргааны акт гаргаж хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авна.

43.9.Банкны мэдээллийн технологийн шалгуур үзүүлэлт, үйл ажиллагааг зохицуулах журмыг Монголбанк батална.

43.10.Энэ хуулийн 21.2 дахь хэсэгт заасан банкны дүрэм, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгийг Монголбанканд бүртгүүлэх журмыг Монголбанк батална.

43.11.Монголбанк энэ хуульд заасан банкны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор улсын бүртгэл, татвар, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагаас шаардлагатай мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр гаргуулан авах эрхтэй.”

**9/47 дугаар зүйлийн 47.8, 47.9 дэх хэсэг:**

“47.8.Монголбанк нь банканд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах болон түүнд ашиглах хэрэгслийг сонгоход тухайн банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгслийг хэрэгжүүлэх үүрэг хүлээхгүй бөгөөд тухайн нөхцөл байдлаас хамаарч өөрчилж болно.

47.9.Банк нь бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, шинэчлэх явцад шаардлагатай бүх мэдээлэл, баримтыг Монголбанкнаас заасан хугацаанд хүргүүлэх үүрэгтэй.”

**10/48 дугаар зүйлийн 48.5 дахь хэсэг:**

“48.5.Монголбанк банк болон банкны удирдлагын үйл ажиллагаа нь банк, санхүүгийн салбарын хууль тогтоомж зөрчсөний улмаас Зөрчлийн тухай хуулийн дагуу тухайн банк, банкны удирдлагад авсан зөрчлийн хэргийн шийдвэрийн талаар хагас жил тутамд олон нийтэд мэдээлнэ.”

**11/53 дугаар зүйлийн 53.4, 53.5, 53.6 дахь хэсэг:**

“53.4.Монголбанк шаардлагатай гэж үзвэл банкны хөрөнгө болон өр төлбөрийн үнэлгээг хэсэгчлэн болон бүхэлд нь хараат бус, хөндлөнгийн, мэргэжлийн этгээдээр хууль, журам, стандартын дагуу хийлгэж болно.

53.5.Энэ хуулийн 53.4-т заасан үнэлгээ хийх зардлыг тухайн банкнаас гаргуулна.

53.6.Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ, түүний хэрэгжилт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийн дүн шинжилгээ, хяналтыг

Монголбанк банкны хяналт шалгалтын чиг үүрэг, арга хэмжээнээс тусад нь зохион байгуулж, хэрэгжүүлнэ.”

**12/61 дүгээр зүйлийн 61.4 дэх хэсэг:**

“61.4 Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний санхүүжилтэд тэргүүн ээлжинд Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгийг ашиглах бөгөөд хүрэлцэхгүй тохиолдолд бүтцийн өөрчлөлтийн сан болон энэ хуульд заасан бусад санхүүжилтийг ашиглана.”

**13/68 дугаар зүйлийн 68.7 дахь хэсэг:**

“68.7.Банкийг албадан татан буулгах арга хэмжээ гурван жил хүртэл хугацаатай байна. Энэ хугацааг нэг удаа нэг жилээр сунгаж болно.”

**14/70 дугаар зүйлийн 70.3 дахь хэсэг:**

“70.3.Энэ хуулийн 68.1 дэх хэсэгт заасны дагуу албадан татан буулгах шийдвэр гарсан бол тухайн банк Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгдөнө.”

**15/73 дугаар зүйлийн 73.4 дэх хэсгийн тайлбар:**

“Тайлбар:“Хувь тэнцүүлэх” гэдэг нь нэхэмжлэлийн шаардлагын хэмжээнд хувиар тооцож төлбөрийг тухайн дараалалд байгаа нэхэмжлэгчдэд хуваан төлөх тооцоололыг хэлнэ.”

**16/75 дугаар зүйлийн 75.5 дахь хэсэг:**

“75.5.Монголбанкны удирдлага, Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасан хорооны гишүүн, зөвлөх, захирал, ажилтан, албан тушаалтан нь энэ хуульд заасан банкны албадлагын арга хэмжээг төлөвлөх, шийдвэрлэх, үйл ажиллагаандаа сайн хүсэл зориг агуулан гаргасан санал, танилцуулга, шийдвэр, дүгнэлт, хэлсэн үг, үйлдэл, байгуулсан гэрээ, хэлцэл болон эс үйлдэлд захиргаа, эрүүгийн болон иргэний хэргийн хариуцлага хүлээхгүй.”

**17/3 дугаар зүйлийн 3.1.21 дэх заалт:**

“3.1.21.“банкийг татан буулгах үйл ажиллагаа” гэж банкны үйл ажиллагааг дуусгавар болгох арга хэмжээг хэрэгжүүлж, түүний хөрөнгөөр нэхэмжлэгч нарын шаардлагыг энэ хуульд заасан төлбөр барагдуулах дарааллын дагуу хангах үйл явцыг;”

**18/6 дугаар зүйлийн 6.1.12 дахь заалт:**

“6.1.12.энэ хуульд заасан үйл ажиллагааг эрхлэхэд зайлшгүй шаардлагатай, хууль тогтоомжоор хориглоогүй бөгөөд Монголбанкнаас зөвшөөрсөн банкны үйл ажиллагаа эрхлэх, төлбөрийн үйлчилгээ үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хамаарал бүхий үйл ажиллагаа.”

**19/20 дугаар зүйлийн 20.1.8 дугаар хэсэг:**

“20.1.8.банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхгүй бол хамгийн их хувьцаа эзэмшиж байгаа 20 хүртэл тооны

хувьцаа эзэмшигч, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, нийт дүн, хэмжээний талаархи мэдээлэл.”

**20/27 дугаар зүйлийн 27.1.8, дахь заалт:**

“27.1.8.энэ хуулийн 67.1.2, 67.1.3-т заасан үндэслэл бүрдсэн.”

**21/31 дүгээр зүйлийн 31.3.10 дахь заалт:**

“31.3.10.Аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх болон эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журмыг тогтоох.”

**22/41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь заалт:**

“41.2.3.тухайн банкны баримт бичигт үндэслэн тохируулга, залруулгын гүйлгээ хийсэн дүгнэлт, удирдлагын захидал, шаардлагатай холбогдох баримт бичгийг тайлангийн хамт ирүүлнэ.”

**23/43 дугаар зүйлийн 43.2.14 дэх заалт:**

“43.2.14.Хяналт шалгалтын хүрээнд Монголбанк эрсдэлээс сэргийлэх бусад арга хэмжээ авах.”

**24/47 дугаар зүйлийн 47.4.2 дахь заалт:**

“47.4.2.хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа болон хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах хэлбэрээр банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, зээл авах хүсэлт гаргах, хөрвөх чадварыг сайжруулах тодорхой арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх;”

**25/48 дугаар зүйлийн 48.1.15<sup>1</sup>, 48.1.15<sup>2</sup>, 48.1.15<sup>3</sup> дахь заалт:**

“48.1.15<sup>1</sup>.хувьцаа эзэмшигчдийн хурлыг энэ хуулийн 30.1-т заасны дагуу зарлан хуралдуулах;

48.1.15<sup>2</sup>.бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ;

48.1.15<sup>3</sup>.банкийг албадан татан буулгах;”

**26/56 дугаар зүйлийн 56.8.5, 56.8.6 дахь заалт:**

“56.8.5.тусгай төлөөлөгч энэ хуулийн 56.8.4-т заасан үнэлгээнд 53.4-т заасан үнэлгээг ашиглаж болно.

56.8.6.энэ хуулийн 69.1-т заасан эрх.”

**27/66 дугаар зүйлийн 66.2.2 дахь заалт:**

“66.2.2.банкны харилцагчтай хийх болон харилцагч хооронд хийгдэх аливаа гүйлгээг хэсэгчлэн болон бүхэлд нь түр зогсоох, гүйлгээ хийж байгаа нэгжийг түр хугацаагаар хаах;”

**28/67 дугаар зүйлийн 67.1.3 дахь заалт:**

“67.1.3.Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх хуульд заасан хугацаа дууссан.”

## **29/70 дугаар зүйлийн 70.1.5 дахь заалт:**

“70.1.5.Банкны эрх хүлээн авах ажиллагаанд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйл хамаарахгүй.”

**2 дугаар зүйл.**Банкны тухай хуулийн **ТАВДУГААР БҮЛГИЙН** гарчгийн “**БАНКНЫ**” гэсний дараа “**ӨӨРИЙН**” гэж, **МӨН БҮЛГИЙН** Нэгдүгээр дэд бүлгийн гарчгийн “**банкны**” гэсний дараа “**өөрийн**” гэж, **ТАВДУГААР БҮЛГИЙН** Тавдугаар дэд бүлгийн гарчгийн “**банкийг**” гэсний дараа “**албадан**” гэж, **2 дугаар зүйлийн 2.1** дэх хэсгийн “Хуулийн этгээдийн” гэсний өмнө “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль,” гэж, **26 дугаар зүйлийн 26.3** болон **26.5** дахь хэсгийн “байршлыг” гэсний өмнө “хаяг,” гэж, **35 дугаар зүйлийн 35.2** дахь хэсгийн “ханшны өөрчлөлт,” гэсний дараа “тухайн” гэж, **37 дугаар зүйлийн 37.4** дэх хэсгийн “шаардах эрхтэй” гэсний дараа “бөгөөд тухай бүр шаардсан баримтыг заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.” гэж, **47 дугаар зүйлийн** гарчгийн “**болон**” гэсний дараа “**банкны**” гэж, **48 дугаар зүйлийн 48.1** дэх хэсгийн “дараахь” гэсний дараа “урьдчилан сэргийлэх” гэж, **49 дүгээр зүйлийн 49.2** дахь хэсгийн “томилох” гэсний дараа “, шаардлагатай тохиолдолд нэг удаа гурван сараар сунгаж болох” гэж, **53 дугаар зүйлийн** гарчгийн “эрх” гэсний дараа “, **зорилго**” гэж, **56 дугаар зүйлийн 56.10** дахь хэсгийн “цалин хөлс,” гэсний дараа “, аюулгүй байдал, нийгмийн баталгаатай” гэж, **66 дугаар зүйлийн 66.6** дахь хэсгийн “хөрөнгийг” гэсний дараа “энэ хуулийн 56.1-т зааснаас бусад этгээд” гэж, **69 дүгээр зүйлийн 69.6** дахь хэсгийн “гүйцэтгэх удирдлага” гэсний өмнө “гүйцэтгэх захирал,” гэж, **20 дугаар зүйлийн 20.1.5** дахь заалтын “аудитын” гэсний дараа “болон татварын” гэж, **21 дүгээр зүйлийн 21.1.2** дахь заалтын “бүтэц” гэсний дараа “, эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт” гэж, **23 дугаар зүйлийн 23.1.2** дахь заалтын “гүйцэтгэх удирдлага” гэсний өмнө “гүйцэтгэх захирал,” гэж, **24 дүгээр зүйлийн 24.1.3** дахь заалтын “хуурамч,” гэсний дараа “үнэн зөв бус, бодит байдалд нийцээгүй,” гэж, “тухайн банкны” гэсний өмнө “мөнгөн хөрөнгийн шилжилт хөдөлгөөн, эх үүсвэрийг шалгаж тодорхойлох боломжгүй,” гэж, **27 дугаар зүйлийн 27.1.3, 27.1.5** дахь заалтын “хуурамч” гэсний дараа “үнэн зөв бус, бодит байдалд нийцээгүй” гэж, **мөн зүйлийн 27.5.2** дахь заалтын “зохистой” гэсний өмнө “өөрийн хөрөнгийн” гэж, **31 дүгээр зүйлийн 31.3.6** дахь заалтын “гүйцэтгэх” гэсний дараа “захирал, гүйцэтгэх” гэж, **32 дугаар зүйлийн 32.1.7** дахь заалтын “мэргэжлээрээ” гэсний дараа “нийт” гэж, **33 дугаар зүйлийн 33.3.1** дэх заалтын “мэргэжлээрээ” гэсний дараа “нийт,” гэж, мөн зүйлийн 33.3.5 дахь заалтын “гүйцэтгэх удирдлагад” гэсний өмнө “гүйцэтгэх захирал,” гэж, **34 дүгээр зүйлийн 34.2.1** дэх заалтын “банк, санхүү,” гэсний дараа “мэдээллийн технологи,” гэж, **мөн зүйлийн 34.2.2** дахь заалтын “банкны” гэсний дараа “нөлөө бүхий” гэж, **43 дугаар зүйлийн 43.2.6** дахь заалтын “бууруулах” гэсний дараа “микро болон макро зохистой бодлогын” гэж, **48 дугаар зүйлийн 48.1.5** дахь заалтын “дотоод” гэсний дараа “аудит” гэж, **62 дугаар зүйлийн 62.1.2** дахь заалтын “зээл олгох” гэсний өмнө “бүтцийн өөрчлөлт хийгдэж байгаа банк, актив, өр төлбөрийг хүлээн авагч хуулийн этгээд, гүүр банканд” гэж, **67 дугаар зүйлийн 67.1.2** дахь заалтын “шаардлагагүй” гэсний дараа “, эсхүл боломжгүй” гэж, **69 дүгээр зүйлийн 69.1.1** дэх заалтын “банкны” гэсний өмнө “банкны зээл, авлагын шаардах эрхийг шаардлагатай тохиолдолд хямдруулан худалдах, өр төлбөрт шилжүүлэх,” **мөн зүйлийн 69.1.12** дахь заалтын “зээлийн” гэсний дараа “болон зээлтэй адилтган тооцох актив, бусад

хөрөнгө, шаардах эрх,” гэж, **мөн зүйлийн** 69.6.3 дахь заалтын “гүйцэтгэх удирдлага” гэсний өмнө “гүйцэтгэх захирал,” гэж, тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Банкны тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/54, 55 дугаар зүйл:**

**“54 дүгээр зүйл.Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний үндэслэл, хүрээ**

54.1.Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах үндэслэл дараах нөхцөл зэрэг бүрдсэн тохиолдолд үүснэ :

54.1.1.энэ хуулийн 27.5-д заасан нөхцөл бүрдсэн;

54.1.2.системд ач холбогдол бүхий үйл ажиллагаатай байх;

54.1.3.бусад хөрөнгө оруулагч болон банкны хувьцаа эзэмшигчидээс хөрөнгө оруулах хүлээлтгүй болсон, хяналт шалгалтын хүрээнд боломжит урьдчилан сэргийлэх арга хэмжээ авагдсан, өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлэх зэрэг бүхий л арга хэмжээг авсан боловч банк ойрын хугацаанд хэвийн үйл ажиллагаагаа хангах боломжгүй болсон;

54.1.4.бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг авах нь нийтийн эрх ашгийг хамгийн ихээр хамгаалахаар байх;

54.1.5.банкны системд нөлөө бүхий банк байх.

54.2.Монголбанк энэ хуулийн 54.1-д заасан үндэслэл үүсээгүй банканд энэ хуулийн 68.1-т заасан арга хэмжээг авахаар шийдвэрлэнэ.

54.3.Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг банк, түүний нэгдлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

54.4.Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Монголбанк банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохгүй.

54.5.Монголбанк энэ зүйлд заасан арга хэмжээг авах тухай шийдвэрээ Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдэд мэдэгдэнэ.

**55 дугаар зүйл.Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хэрэгсэл**

55.1.Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах хэрэгслийг дангаар болон хэд хэдэн хэрэгслийг хамтад нь ашиглаж болно:

55.1.1.банкны актив, өр төлбөрийг худалдах, шилжүүлэх;

55.1.2.гүүр банк байгуулах замаар банкны хөрөнгө, өр төлбөрийг шилжүүлэх;

55.1.3.хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх;

55.1.4.өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлэх;

55.2.Банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах болон энэ хуулийн 55.1-д заасан хэрэгслийг ашиглахад хувьцаа эзэмшигчдийн хурлыг

хуралдуулахгүй бөгөөд банкны хувьцаа эзэмшигч, үүргийн гүйцэтгэл шаардах эрх бүхий этгээдийн зөвшөөрлийг авах шаардлагагүй.

55.3.Монголбанк энэ хуульд нийцүүлэн банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах, хэрэгжүүлэх журмыг батална.”

## **2/57, 58 дугаар дугаар зүйл:**

### **“57 дугаар зүйл.Банкны актив, өр төлбөрийг худалдах, шилжүүлэх**

57.1.Тусгай төлөөлөгч банкны актив, өр төлбөрийг бусад этгээдэд шилжүүлж, худалдаж болно.

57.2.Энэ хуулийн 57.1-т заасны дагуу шилжүүлэх, худалдахад энэ хуулийн 56.8.4-т заасан үнэлгээг ашиглаж болно.

57.3.Банкны актив, өр төлбөрийг шилжүүлэх, худалдахад шаардагдах санхүүжилтийн нөхцөл, хэлбэр, хэмжээг тусгай төлөөлөгчийн саналыг харгалзан Монголбанк тодорхойлно.

57.4.Банкны актив, өр төлбөрийг шилжүүлэх, худалдах шийдвэр нь тухайн банкны тэнцэл болон тэнцлийн гадуурх зүйлтэй холбоотойгоор өмнө байгуулсан гэрээ, хэлцэл, шийдвэрийн зохицуулалтаас үл хамааран хэрэгжинэ.

57.5.Банкны актив, өр төлбөрийг шилжүүлсэн, худалдсан нь банкнаас урьд нь бусадтай байгуулсан гэрээ, хэлцлийг хугацаанаас өмнө татгалзах, цуцлах үндэслэл болохгүй.

57.6.Энэ хуулийн 57.1-т заасан арга хэмжээг авахад дараах зарчмыг баримтална:

57.6.1.өр төлбөрт барьцаалагдсан эд хөрөнгийг тухайн өр төлбөр, уг үүргийн гүйцэтгэлийг хангуулах бусад дагалдах эрхийн хамт хэсэгчлэн болон бүхэлд нь шилжүүлэх, худалдах;

57.6.2.хүүгийн своп, валютын своп, валютын опцион болон Монголбанкнаас тодорхойлсон бусад санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлийн төлбөр харилцан тооцох, эрх, үүргийг хэсэгчлэн болон бүхэлд нь шилжүүлэх.

57.7.Энэ зүйлд заасан арга хэмжээний хүрээнд буцаан төлөгдсөн хөрөнгийн хэмжээ нь тухайн банкиг шууд татан буулгасны үр дүнд буцаан төлөгдөх боломжтой байсан хөрөнгийн хэмжээнээс багассан болох нь тогтоогдсон тохиолдолд тухайн банкнаас төлбөр гаргуулах шаардлага нь бусдад шилжээгүй үүрэг гүйцэтгүүлэгч уг зөрүүгээр нөхөн төлбөр гаргуулахыг шаардах эрхтэй.

### **58 дугаар зүйл.Гүүр банк байгуулах**

58.1.Тусгай төлөөлөгч нь банкны бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх зорилгоор хуульд заасан нөхцөл шаардлагын хүрээнд гүүр банк байгуулж болно.

58.2.Гүүр банк байгуулах тусгай зөвшөөрлийн хугацаа хоёр хүртэлх жил байна, шаардлагатай тохиолдолд нэг удаа нэг жилээр сунгаж болно.

58.3.Хадгаламжийн даатгалын корпораци гүүр банкны хувьцааг эзэмшинэ.

58.4.Бүтцийн өөрчлөлт хийгдэж байгаа банкнаас банкны системд ач холбогдол бүхий үйл ажиллагааг гүүр банканд шилжүүлнэ.

58.5.Гүүр банканд энэ хуулийн дагуу үйл ажиллагаа эрхэлж байгаа банканд тавигдах аливаа шаардлага, хязгаарлалт хамаарахгүй.

58.6.Гүүр банкны үйл ажиллагаанд Монголбанк хяналт тавина.

58.7.Гүүр банкны нийт өр төлбөр нь нийт хөрөнгөөсөө хэтрэхгүй.

58.8.Дараах нөхцөлд гүүр банкны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

58.8.1.гүүр банк нь өөр банктай нэгдсэн;

58.8.2.гүүр банкны дийлэнх эсхүл бүх хөрөнгө, өр төлбөрийг гуравдагч этгээдэд шилжүүлсэн, худалдсан;

58.8.3.тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;

58.8.4.гүүр банкны хөрөнгийг төлүүлж барагдуулах, эсхүл худалдсан, шилжүүлсэн, өр төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангасан.

58.9.Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор гүүр банк нь энэ хуулийн 6.1-д заасан, Монголбанк зөвшөөрсөн үйл ажиллагааг эрхэлнэ.

58.10.Гүүр банкны нэр нь бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ хэрэгжүүлж байгаа банкны оноосон нэрэнд "Гүүр" гэсэн үг агуулна."

### **3/68 дугаар зүйлийн гарчиг:**

**"68 дугаар зүйл.Банкийг албадан татан буулгах, банкны эрх хүлээн авагчийг томилох шийдвэр"**

### **4/10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг:**

"10.2.Банк хугацаандаа төлөгдөөгүй зээл, хүүгийн төлбөрт гэрээ болон шүүхийн шийдвэрийн үндсэн дээр шилжүүлэн авсан эд хөрөнгө, хувьцаа, түүний ногдол ашгийг авлага барагдуулах зорилгоор, худалдан борлуулах нөхцөлтэйгээр эзэмшиж, өмчилж болох бөгөөд энэ нь энэ хуулийн 17.4-т заасанд хамаарахгүй."

### **5/17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг:**

"17.4 Энэ хуулийн 15.1-д заасны дагуу худалдан авах үнэт цаасны нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй бөгөөд нэг компанийн гаргасан хувьцааны 10 хувиас дээшгүй байна. Энэ хязгаарлалтад энэ хуулийн 17.5-д заасан болон Засгийн газар, Төв банкны үнэт цаас хамаарахгүй."

### **6/17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсэг:**

"17.7.Энэ хуулийн 17.1-17.4-д заасан хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих, томоохон харилцагчийг тодорхойлох журмыг Монголбанк батална."



**7/24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:**

“24.2.Банк энэ хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй, хуулийн хүрээнд Монголбанкнаас албадлагын арга хэмжээг авч байгаа бол Монголбанк банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзах буюу өргөдөл хүлээн авахгүй.”

**8/30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэг:**

“30.4.Монголбанкнаас бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ болон албадан татан буулгах арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахгүй.”

**9/31 дүгээр зүйлийн 31.8 дахь хэсэг:**

“31.8.Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн тухай хуулийн 81.2-т заасан хороодоос гадна эрсдэлийн удирдлагын хороотой байх бөгөөд уг хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна.”

**10/32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэг:**

“32.3.Энэ хуулийн 33 дугаар зүйлд зааснаас бусад банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа этгээд нь энэ хуулийн 32.1-д заасан шалгуурыг хангаж байгаа эсэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хороо хяналт тавьж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх үүрэгтэй байна. Шинээр үүсгэн байгуулж байгаа банкны хувьд энэхүү үүргийг үүсгэн байгуулагчдын хурал хариуцна.”

**11/35 дугаар зүйлийн 35.8 дахь хэсэг:**

“35.8.Банкны хувьцаа эзэмшигч нь хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаанд хамаарах үнэт цаас, хуримтлагдсан ашиг, нэмж төлөгдсөн капитал, нөөц сан, дахин үнэлгээний сан, бусад сан болон өөрийн хөрөнгийн зүйл ангид багтах бүхий л эздийн өмчлөлд хамаарах бүхий л хэсгээр алдагдлыг хариуцна.”

**12/36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэг:**

“36.2.Энэ хуульд заасан бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ хэрэгжүүлж байгаа банканд энэ зүйлд заасан хязгаарлалт хамаарахгүй.”

**13/43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэг:**

“43.6.Монголбанк банкны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор энэ хуульд заасан хүрээнд шаардлагатай журам, аргачлал, захиргааны хэм, хэмжээний актыг батална.”

**14/47 дугаар зүйлийн 47.5, 47.6 дахь хэсэг:**

“47.5.Банк нөхөн сэргээх төлөвлөгөөг жилд нэгээс доошгүй удаа туршиж, үр дүнгийн талаарх мэдээллийг Монголбанканд хүргүүлнэ.

47.6.Монголбанк энэ хуулийн 54.1.2-т заасан үйл ажиллагаа бүхий банканд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний урьдчилсан төлөвлөгөөг боловсруулж, тухай бүр шинэчлэнэ.”

**15/53 дугаар зүйлийн 53.1, 53.2, 53.3 дахь хэсэг:**

“53.1.Монголбанк энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу банканд энэ хуулийн 3.1.3-т заасан арга хэмжээ авах шийдвэр гаргах эрхтэй.

53.2.Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ нь дараах зорилготой байна:

53.2.1.санхүүгийн тогтвортой байдлыг хангах;

53.2.2.харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах;

53.2.3. бүтцийн өөрчлөлтийн санхүүжилтэд төрөөс гарах зардлыг бага байлгах;

53.3.Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтлана:

53.3.1.энэ хуулийн 35.8-д заасан алдагдлыг хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд хүлээлгэх;

53.3.2.энэ хуульд өөрөөр заагаагүй бол нэг дараалалд байгаа өр төлбөр нэхэмжлэгч нарт тэгш хандах бөгөөд тэдгээр нь хувьцаа эзэмшигчдийн дараа алдагдлыг хариуцах;

53.3.3.банкны өр төлбөр нэхэмжлэгчдийн хүлээх хохирол нь банкныг татан буулгаснаас бага байлгахыг эрмэлзэх;

53.3.4.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан даатгагдсан хадгаламжийн дүнгээр бүрэн хамгаалагдсан байх;

53.3.5.банкны удирдлага, эрх бүхий албан тушаал эрхэлж байгаа этгээд нь бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх туслалцааг үзүүлэх үүрэгтэй;

53.3.6.банкны удирдлага болон бусад этгээдийн гаргасан үйлдэл нь банканд энэ хуулийн 27.5-д заасан нөхцөл үүсэхэд нөлөөлсөн бол энэ хуулийн 69.5-д заасан арга хэмжээг авах.”

**16/68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсэг:**

“68.3.Банкны эрх хүлээн авагч нь банк, түүний эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх болон банкны хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй байх бөгөөд энэхүү эрх нь зөвхөн банкны активын эргэн төлөлт, хөрөнгө худалдсан, хөрөнгийн үр шимийн орлогоос нэхэмжлэгчдийн шаардлагыг хангах, орлогыг хуваарилах чиг үүргийг хэрэгжүүлэхэд хамаарна.”

**17/3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт:**

“3.1.3."банканд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах" гэж банкны системийн тогтвортой байдлыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, төрөөс гарах санхүүжилтийг бага байлгах зорилгоор энэ

хуульд заасан үндэслэл бүрдсэн банканд Монголбанкнаас бүтцийн өөрчлөлтийн арга хэрэгслийг ашиглан арга хэмжээ авахыг;

**18/3 дугаар зүйлийн 3.1.15 дахь заалт:**

“3.1.15."найдваргүй, хэвийн бус үйл ажиллагаа" гэж Монголбанкнаас банкны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахуйц эсхүл/болон банкиг төлбөрийн чадварын хүндрэлд оруулж болзошгүй гэж үзсэн аливаа үйл ажиллагааг;”

**19/3 дугаар зүйлийн 3.1.18 дахь заалт:**

“3.1.18."Системд ач холбогдол бүхий үйл ажиллагаа" гэж зах зээлд эзлэх хувь, хэмжээ, үйл ажиллагааныхаа хэлхээ холбооноос хамаарч аливаа саатал нь банкны тогтолцооны тогтвортой байдлыг алдагдуулж, улсын эдийн засагт бодит сөрөг нөлөө үзүүлж болзошгүй, уг үйл ажиллагааг бусад этгээд гүйцэтгэхэд хөрөнгө, хугацаа их шаардагдах банкны үйл ажиллагааны чиглэлийг;”

**20/16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалт:**

“16.1.4.харилцагчийн зөвшөөрөлгүйгээр данснаас нь зарлагын гүйлгээ хийхгүй бөгөөд шүүхийн шийдвэр биелүүлэх хууль тогтоомжийн хүрээнд өрийг үл маргах журмаар гаргуулахад хамаарахгүй.”

**21/27 дугаар зүйлийн 27.1.7 дахь заалт:**

“27.1.8.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, энэ нь санхүүгийн системийг эрсдэлд оруулах эсхүл олон улсын байгууллагын өмнө Монгол Улсын хүлээсэн үүргийн ноцтой зөрчлийг бий болгохоор байгаа бол.”

**22/29 дүгээр зүйлийн 29.2.10 дахь заалт:**

“29.2.10.их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцлийг Компанийн тухай хуульд заасны дагуу хэлэлцэх.”

**23/32 дугаар зүйлийн 32.1.5 дахь заалт:**

“32.1.5.тухайн нэр дэвшигчийн зөрчлийн улмаас банк, банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болсон эсхүл банк, банк бус санхүүгийн байгууллага төлбөрийн чадваргүй болсон;”

**24/43 дугаар зүйлийн 43.2.8 дахь заалт:**

“43.2.8. Банкны хөрвөх чадварын шаардлагыг тогтоож, хангуулах;”

**25/48 дугаар зүйлийн 48.1.3 дахь заалт:**

“48.1.3.нөхөн сэргээх төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг даалгах;”

**26/48 дугаар зүйлийн 48.1.14, 48.1.15 дахь заалт:**

“48.1.14.ногдол ашиг хуваарилахыг хориглох;

48.1.15.хувьцаа эзэмшигчдийн хурлыг энэ хуулийн 30.1-т заасны дагуу зарлан хуралдуулах;”

#### **27/56 дугаар зүйлийн 56.8.4 дэх заалт:**

“56.8.4.тусгай төлөөлөгч нь банкны актив болон өр төлбөрийн үнэлгээг хэсэгчлэн болон бүхэлд нь хараат бус, хөндлөнгийн, мэргэжлийн этгээдээр хууль, журам, стандартын дагуу хийлгэж болно.”

#### **28/69 дүгээр зүйлийн 69.1.10 дахь заалт:**

“69.1.10.банкны гадаад валютаар илэрхийлэгдсэн өр төлбөр, хүлээж болзошгүй үүргийг барагдуулахдаа Монголбанкнаас албадлагын арга хэмжээ авах шийдвэр гарсан өдрийн Монголбанкнаас зарласан ханшаар төгрөгт хөрвүүлэн тооцно.”

**4 дүгээр зүйл.** Банкны тухай хуулийн **ЗУРГАДУГААР БҮЛГИЙН Нэгдүгээр дэд бүлгийн** гарчгийн “**банкны тогтворжуулалт,**” гэснийг “**банкийг нөхөн сэргээх, банкны**” гэж, **6 дугаар зүйлийн** 6.4 дэх хэсгийн “авна” гэснийг “авах бөгөөд холбогдох зөвшөөрлийг олгосон тохиолдолд Монголбанканд мэдэгдэнэ” гэж, **7 дугаар зүйлийн** 7.2 дахь хэсгийн “удирдлага, хянан шалгах зөвлөл, ” гэснийг “захирал” гэж, **15 дугаар зүйлийн** 15.1 дэх хэсгийн “Энэ хуулийн 17.4-т заасан хязгаарлалтын хүрээнд хөрөнгийн” гэснийг “Хөрөнгийн” гэж, **17 дугаар зүйлийн** 17.11 дэх хэсгийн “Монголбанк” гэснийг “Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааг тооцохдоо” гэж, **26 дугаар зүйлийн** 26.2 дахь хэсгийн “гэсэн” гэснийг “болон аливаа хэлбэрээр банк гэх агуулга бүхий” гэж, **31 дүгээр зүйлийн** 31.5 дахь хэсгийн “79” гэснийг “81” гэж, **34 дүгээр зүйлийн** гарчгийн “удирдлага” гэснийг “захирал” гэж, **мөн зүйлийн** 34.1 дэх хэсгийн “удирдлага” гэснийг “захирал Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан” гэж, **мөн зүйлийн** 34.2 дахь хэсгийн “удирдлага” гэснийг “захирал” гэж, **мөн зүйлийн** 34.3 дахь хэсгийн “удирдлага” гэснийг “захирал” гэж, **35 дугаар зүйлийн** 35.4 дэх хэсгийн “хэмжээг” гэснийг “хэмжээнд” гэж, “хорогдуулж тодорхойлно” гэснийг “хорогдуулах зэргээр тохируулга хийнэ” гэж, **37 дугаар зүйлийн** 37.3 дахь хэсгийн “10” гэснийг “5” гэж, **40 дүгээр зүйлийн** 40.1 дэх хэсгийн “оролцогчийн” гэснийг “оролцогч” гэж, **45 дугаар зүйлийн** 45.4 дэх хэсгийн “Монголбанк” гэснийг “холбогдох мэдээллийг Монголбанканд” гэж, **47 дугаар зүйлийн** гарчгийн “**тогтворжуулах**” гэснийг “**нөхөн сэргээх**” гэж, **мөн зүйлийн** 47.2 дахь хэсгийн “толгой компани” гэснийг “оролцогчид, тэдний” гэж, **мөн зүйлийн** 47.7 дахь хэсгийн “47.5” гэснийг “47.6” гэж, **49 дүгээр зүйлийн** 49.2 дахь хэсгийн “нэг жил” гэснийг “гурван сар” гэж, **50 дугаар зүйлийн** 50.2 дахь хэсгийн “мэдээлж болно” гэснийг “мэдээлнэ” гэж, **51 дүгээр зүйлийн** 51.3 дахь хэсгийн “дүрэм” гэснийг “шийдвэр” гэж, **52 дугаар зүйлийн** 52.8 дахь хэсгийн “үйл ажиллагааны” гэснийг “үйлдлийн” гэж, **60 дугаар зүйлийн** 60.3 дахь хэсгийн “55.4-т” гэснийг “16.1.2-т” гэж, **61 дүгээр зүйлийн** 61.1 дэх хэсгийн “тусгай зориулалтын” гэснийг “гүүр” гэж, “тогтворжуулалтын” гэснийг “бүтцийн өөрчлөлтийн” гэж, **мөн зүйлийн** 61.3 дахь хэсгийн “үзвэл” гэснийг “үзсэн бөгөөд доор дурдсан нөхцөл нэгэн зэрэг” гэж, **62 дугаар зүйлийн** гарчгийн “тогтворжуулалтын” гэснийг “бүтцийн өөрчлөлтийн” гэж, **мөн зүйлийн** 62.1 дэх хэсгийн “банкны санхүүгийн байдлыг сайжруулах, тогтворжуулах” гэснийг “банкны системийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн” гэж, **66 дугаар зүйлийн** 66.1 дэх хэсгийн “банктай” гэснийг “банк, түүний нэгдэлтэй” гэж, **мөн зүйлийн** 66.6 дахь хэсгийн “Банканд авах” гэснийг “Бүтцийн өөрчлөлтийн” гэж, **68 дугаар зүйлийн** 68.1 дэх хэсгийн “томилно” гэснийг “томилох бөгөөд банкны эрх хүлээн авагч нь банкны үйл ажиллагааг дуусгавар болгох арга хэмжээг хэрэгжүүлж, түүний хөрөнгөөр нэхэмжлэгч нарын шаардлагыг энэ хуульд заасан

төлбөр барагдуулах дарааллын дагуу хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ” гэж, **мөн зүйлийн** 68.5 дахь хэсгийн “авагчийн цалин хөлсийг Монголбанк тогтоож, банкны эрх хүлээн авахтай” гэснийг “авах, банкныг албадан татан буулгах болон Монголбанкнаас тогтоосон банкны эрх хүлээн авагчийн цалин хөлс, аюулгүй байдал, нийгмийн баталгаатай” гэж, **74 дүгээр зүйлийн** 74.1 дэх хэсгийн “шилжүүлсний” гэснийг “шилжүүлсэн, эсхүл энэ хуулийн 68.7-д заасан хугацаа дууссаны” гэж, **75 дугаар зүйлийн** 75.1 дэх хэсгийн “Монголбанк, эрх бүхий этгээдийн” гэснийг “Монголбанкны” гэж, **3 дугаар зүйлийн** 3.1.16 дахь заалтын “байдлыг нь сайжруулах” гэснийг “бодит байдлыг нь тогтоох” гэж, **мөн зүйлийн** 3.1.7 дахь заалтын “нөхцөлийг хангах” гэснийг “нэгдэлд хамаарагдаж байгаа” гэж, **мөн зүйлийн** 3.1.18 дахь заалтын “үндсэн” гэснийг “системд ач холбогдол бүхий” гэж, **23 дугаар зүйлийн** 23.1.4 дэх заалтын “хууль ёсны үйл ажиллагаанаас бий болсон хөрөнгө болохыг нотлох хангалттай баримт бичиг бүрдүүлсэн эсэх.” гэснийг “энэ хуулийн 19.1.4-т заасан шаардлагыг хангаж байгааг баримтаар нотолсон эсэх,” гэж, **20 дугаар зүйлийн** 20.1.7 дахь заалтын “үүслийг” гэснийг “үүсэл, шилжилт хөдөлгөөнийг бүрэн тодорхойлох” **31 дүгээр зүйлийн** 31.3.2 дахь заалтын “удирдлагыг” гэснийг “захирлыг” гэж, **мөн зүйлийн** 31.3.3 дахь заалтын “удирдлагын” гэснийг “захирлын” гэж, **33 дугаар зүйлийн** 33.3.1 дэх заалтын “эрх зүйн” гэснийг “эрх зүй, мэдээллийн технологийн” гэж, “жилд банк санхүүгийн байгууллагад” гэснийг “жил” гэж, **34 дүгээр зүйлийн** 34.2.1 дэх заалтын “засгийн” гэснийг “засаг, хууль, эрх зүйн” гэж, **37 дугаар зүйлийн** 37.2.2 дахь заалтын “удирдлага” гэснийг “захирал” гэж, **43 дугаар зүйлийн** 43.2.2 дахь заалтын “байдалтай” гэснийг “хүрэлцээний үзүүлэлттэй” гэж, **мөн зүйлийн** 43.2.3 дахь заалтын “дээш хэмжээгээр” гэснийг “дээгүүр” гэж, **мөн зүйлийн** 43.2.5 дахь заалтын “зөвлөмж өгөх” гэснийг “даалгах” гэж, **мөн зүйлийн** 43.2.6 дахь заалтын “банкны” гэснийг “банк, банкны системийн” гэж, **мөн зүйлийн** 43.2.9 дэх заалтын “ирүүлэх, тайлагнах” гэснийг “гаргуулж авах” гэж, **мөн зүйлийн** 43.2.10 дахь заалтын “хангаж ажиллах” гэснийг “хангуулах” гэж, **мөн зүйлийн** 43.2.11 дэх заалтын “хангах” гэснийг “хангуулах” гэж, **мөн зүйлийн** 43.2.12 дахь заалтын “удирдлагыг” гэснийг “захирлыг” гэж, **48 дугаар зүйлийн** 48.1.1, 48.1.2 дахь заалтын “дутагдлыг” гэснийг “түүнийг үүсгэж болзошгүй нөхцөлийг,” гэж, **мөн зүйлийн** 48.1.6 дахь заалтын “хангалттай байх түвшинд” гэснийг “хүрэлцээнд” гэж, **мөн зүйлийн** 48.1.12 дахь заалтын “удирдлагыг” гэснийг “захирлыг” гэж, **56 дугаар зүйлийн** 56.2.4 дэх заалтын “удирдлага” гэснийг “захирал” гэж, “ажилтантай” гэснийг “эрх бүхий албан тушаалтантай” гэж, **62 дугаар зүйлийн** 62.1.4 дэх заалтын “тусгай зориулалтын” гэснийг “гүүр” гэж, **66 дугаар зүйлийн** 66.1.1 дэх заалтын “банкинд” гэснийг “банк, банкны нэгдэлд” гэж, **мөн зүйлийн** 66.1.2 дахь заалтын “банкны” гэснийг “банк, банкны нэгдлийн” гэж, **68 дугаар зүйлийн** 68.1.2 дахь заалтын “хэмжээ” гэснийг “хэмжээг” гэж, **73 дугаар зүйлийн** 73.1.10 дахь заалтын “албан татвар” гэснийг “банкныг албадан татан буулгах шийдвэр гарсан өдрөөс өмнөх албан татварын өглөг” гэж, **3 дугаар зүйлийн** 3.1.2.в заалтын “хувьцааных нь” гэснийг “гаргасан хувьцааны” гэж, **мөн зүйлийн** 3.1.2.г заалтын “хувьцааных” гэснийг “гаргасан хувьцааны” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Банкны тухай хуулийн **47 дугаар зүйлийн** 47.1 дэх хэсэг, **48 дугаар зүйлийн** 48.1 дэх хэсэг, **63 дугаар зүйлийн** 63.5 дахь хэсэг, **16 дугаар зүйлийн** 16.1.1 дэх заалтын “төлбөр түргэн гүйцэтгэх” гэснийг “хөрвөх” гэж тус тус өөрчилсүгэй.

**6 дугаар зүйл.** Банкны тухай хуулийн **47 дугаар зүйлийн** 47.1, 47.3, 47.4 дэх хэсгийн “тогтворжуулах” гэснийг “нөхөн сэргээх” гэж тус тус өөрчилсүгэй.

**7 дугаар зүйл.**Банкны тухай хуулийн **11 дүгээр зүйлийн** 11.4 дэх хэсгийн “Монголбанкнаас зөвшөөрсөн тохиолдолд” гэснийг, **17 дугаар зүйлийн** 17.6 дэх хэсгийн “байж болно” гэснийг, **30 дугаар зүйлийн** гарчгийн “хувь” гэснийг **45 дугаар зүйлийн** 45.4 дэх хэсгийн “банкны гаргасан хүсэлтийн дагуу” гэснийг, **47 дугаар зүйлийн** 47.1 дэх хэсгийн “хариу” гэснийг, **61 дүгээр зүйлийн** 61.3 дахь хэсгийн “доор дурдсан нөхцөлтэй” гэснийг, **62 дугаар зүйлийн** 62.3 дахь хэсгийн “найдвартай,” гэснийг, **67 дугаар зүйлийн** 67.2 дахь хэсгийн “авах” гэснийг, **73 дугаар зүйлийн** 73.1 дэх хэсгийн “банкны эрх хүлээн авагч банкны хөрөнгийг худалдан борлуулсан, захиран зарцуулсан, төлөгдсөн орлогоос” гэснийг, **75 дугаар зүйлийн** 75.4 дэх хэсгийн “бүрэн эрхт төлөөлөгч” гэснийг, **16 дугаар зүйлийн** 16.1.1 дэх заалтын “зохих хэмжээ, хэлбэрээр” гэснийг, **19 дүгээр зүйлийн** 19.1.1 дэх заалтын “хуулийн этгээд бол” гэснийг, **28 дугаар зүйлийн** 28.3.3 дахь заалтын “банкны” гэснийг, **33 дугаар зүйлийн** 33.3.6 дахь заалтын “төрийн” гэсний дараах “,” тэмдэгийг, **34 дүгээр зүйлийн** 34.2.2 дахь заалтын “банк,” болон “нэгдмэл сонирхолтой этгээд биш” гэснийг, **48 дугаар зүйлийн** 48.1.12 дахь заалтын “түдгэлзүүлэх,” гэснийг, **69 дүгээр зүйлийн** 69.1.14 дэх заалтын “банкны хувьцаа эзэмшигчдэд алдагдлыг хүлээлгэж, тэдгээрийн оруулсан хөрөнгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгө, бусад сангаас” гэснийг тус тус хассугай.

**8 дугаар зүйл.**Банкны тухай хуулийн **ЗУРГАДУГААР БҮЛГИЙН 3 дугаар дэд бүлэг, 11 дүгээр зүйлийн** 11.6, 11.7 дахь хэсэг, **27 дугаар зүйлийн** 27.4 дэх хэсэг, **33 дугаар зүйлийн** 33.4, 33.6 дахь хэсэг, **56 дугаар зүйлийн** 56.7 дахь хэсэг, **7 дугаар зүйлийн** 7.2.6, 7.2.8, 7.2.10, 7.2.11 дэх заалт, **62 дугаар зүйлийн** 62.1.5 дахь заалт, **73 дугаар зүйлийн** 73.1.4.а дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**9 дүгээр зүйл.**Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**Гарын үсэг**